

2025 / 0424

№ 25/15

Улаанбаатар хот

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

*Компанийн хувьцааг эргүүлэн худалдан авах тухай*

Компанийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1, 49.5 болон 49.10.1 дэх заалт, 55 дугаар зүйлийн 55.2 болон 55.8 дахь хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.7 дахь заалт, Ард Санхүүгийн Нэгдэл ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрэм болон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны 4 сарын 24-ний өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

- Хувьцааны хөрвөх чадварыг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулагчийн эзэмшиж буй хөрөнгийн үнэ цэнийг өсгөх зорилгоор компанийн ТУЗ-ийн баталсан бизнес төлөвлөгөөний хүрээнд хийгдэж буй бүтцийн өөрчлөлтийг нийцүүлэн нийт 12,658,754,800 төгрөг хүртэлх үнийн дүнтэй тэнцэх Компанийн хувьцааг энэ тогтоолын Нэгдүгээр хавсралтад заасан нөхцлийн дагуу олон нийтээс худалдан авч, хувьцааны төлбөрийг үнэт цаасаар хийж халааслахаар **ШИЙДВЭРЛЭСҮГЭЙ.**
- Компанийн “Хувьцаа эргүүлэн худалдан авч, халааслах журам”-г энэ тогтоолын Хоёрдугаар хавсралтаар баталж, дагаж **МӨРДСҮГЭЙ.**
- Компанийн хувьцааг эргүүлэн худалдан авах гэрээ, хэлцэл болон холбогдох бусад баримт бичигт компанийг төлөөлж, гарын үсэг зурах, хувьцааг хууль тогтоомжийн дагуу шилжүүлэн авах, халаасны хувьцаагаар бүртгүүлэх, холбогдох төлбөр хийх ажлыг гүйцэтгэх захирал (Б.Золбоо), хуульч (Ө.Ашхүү), ерөнхий нягтлан бодогч (Б.Оюунсууд) нарт **ДААЛГАСУГАЙ.**
- Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Санхүүгийн Зохицуулах Хороо, Монголын Хөрөнгийн Бирж болон Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвтэй харилцан хамтран ажиллахыг Гүйцэтгэх захирал (Б.Золбоо)-д **ДААЛГАСУГАЙ.**

ДАРГА

Ч.ГАНХУЯГ





"Ард Санхүүгийн Нэгдэл" ХК-ийн Төлөөний Усирдах  
Зөвлөлийн 2025 оны 4-р сарын 24-ны өдрийн 101 тоот  
төслийн нийтийн түүхээр хөгжлийн  
Улаанбаатар

№		АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ ХК-ИЙН ХУВЬЦААГ ЭРГҮҮЛЭН ХУДАЛДАН АВЧ, ХАЛААСЛАХ НӨХЦӨЛ
1	Хувьцааг эргүүлэн худалдан авах үнэ /төгрөг/	2,920 төгрөг
2	Эргүүлэн худалдан авах нийт хувьцааны тоо	4,335,190 ширхэг хүртэл
3	Эргүүлэн худалдан авах нийт үнийн дүн /төгрөг/	12,658,754,800 төгрөг хүртэл
4	Эргүүлэн худалдаж авах хувьцааны төлбөр	Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн эзэмшилийн Хөвсгөл ХК /MSE:HVL/-ийн нэгж бүрийн 146 төгрөгийн үнэтэй энгийн хувьцаа
5	Эргүүлэн худалдан авч буй болон төлбөрт өгч буй үнэт цаасны харьцаа	Ард Санхүүгийн Нэгдэл ХК (MSE:AARD)-ийн 1 ширхэг хувьцаа тутамд 20 ширхэг Хөвсгөл ХК (MSE:HVL)-ийн хувьцаа
6	Хувьцааг олон нийтээс эргүүлэн худалдаж авах захиалгын хугацаа	2025 оны 4-р сарын 28-ны өдрөөс 2025 оны 5-р сарын 30-ны өдрийг дуустал
7	Төлбөр тооцох хугацаа	2025 оны 5-р сарын 30-ны өдрөөрх тархалтын мэдээлэлд үндэслэн төлбөрийг тооцно.
8	Мэдээлэл түгээх	Хувьцааг олон нийтээс худалдан авах захиалгыг авч холбогдох бүртгэлийг эрх бүхий байгууллага бүртгэнээс хойш ажлын 3 хоногийн дотор Компанийн <a href="http://www.ardholdings.com">www.ardholdings.com</a> болон Монголын хөрөнгийн биржийн <a href="http://www.mse.mn">www.mse.mn</a> цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлнэ.
9	Захиалга хүлээн авах байгууллага	Ард Секюритиз УЦК ХХК Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Сентрал Тауэр, 17 давхар
10	Захиалга хүлээн авах хэлбэр	Бичгээр (Сентрал Тауэр 101 тоот) эсхүл цахимаар ( <a href="mailto:support@ardsecurities.com">support@ardsecurities.com</a> )



**“АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ” ХК-ИЙН ХУВЬЦААГ  
ЭРГҮҮЛЭН ХУДАЛДАН АВЧ, ХАЛААСЛАХ ЖУРАМ**

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү “Ард Санхүүгийн Нэгдэл” ХК-ийн хувьцааг эргүүлэн худалдан авч, халааслах журам /цаашид “Журам” гэх/-аар “Ард Санхүүгийн Нэгдэл” ХК (цаашид “Компани” гэх)-ийн энгийн хувьцааг Үнэт цаасны төвлөрсөн хадгаламж төв /цаашид “ҮЦТХТ” гэх/-өөр дамжуулан Журмын 2.2 дахь хэсэгт заасны дагуу эргүүлэн худалдан авч, халааслах ажиллагааг зохицуулна.
- 1.2. Энэхүү журам нь Монгол Улсын Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Иргэний хууль, Компанийн Дүрэм, Үнэт цаасны бүртгэлийн журам, Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын тухай журам болон холбогдох бусад хууль тогтоомжийн хүрээнд үйлчилийн хувьцааг эргүүлэн худалдан авч, халааслах ажиллагааг зохицуулна.
- 1.3. Энэхүү журам нь холбогдох хууль, эрх зүйн хэм хэмжээний акттай зөрчилдсөн тохиолдолд холбогдох хууль, эрх зүйн хэм хэмжээний актыг баримтална.

ХОЁР. ЖУРМЫН ЗОРИЛГО, ҮЙЛЧЛЭХ ХҮРЭЭ

- 2.1. Хувьцааны хөрвөх чадварыг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулагчийн эзэмшиж буй хөрөнгийн үнэ цэнийг өсгөх зорилгоор компанийн ТУЗ-ийн баталсан бизнес төлөвлөгөөний хүрээнд хийгдэж буй бүтцийн өөрчлөлтийг нийцүүлэхэд оршино.
- 2.2. Энэхүү журам нь Бирж дээр нээлттэй арилжаалагдаж буй Компанийн хувьцааг Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн эзэмшлийн Хөвсгөл ХК /MSE:HVL/-ийн энгийн хувьцаагаар төлбөрийг хийж, эргүүлэн худалдаж авах үйл ажиллагаанд үйлчилийн хувьцааг эргүүлэн худалдан авч, халааслах ажиллагааг зохицуулна.

ГУРАВ. ХУВЬЦААГ ЭРГҮҮЛЭН ХУДАЛДАН АВАХ НӨХЦӨЛ

- 3.1. Эргүүлэн худалдаж авах хувьцааны нийт хэмжээ нь Компанийн гаргасан нийт энгийн хувьцааны 16 хувиас хэтрэхгүй байна.
- 3.2. Эргүүлэн худалдаж авах хувьцааны төлбөрийг үнэт цаасаар буюу Компанийн эзэмшлийн Хөвсгөл ХК-ийн энгийн хувьцаагаар төлнө.
- 3.3. Эргүүлэн худалдаж авах үйл ажиллагааг дараах хязгаарын хүрээнд явуулна:
  - 3.3.1. Эргүүлэн худалдаж авах үнэ 2,920 төгрөг байна.

- 3.3.2. Эргүүлэн худалдан авах нийт үнийн дүн 12,658,754,800 төгрөг хүртэл байна.
- 3.3.3. Эргүүлэн худалдан авах нийт хувьцааны тоо 4,335,190 ширхэг хүртэл байна.
- 3.3.4. Эргүүлэн худалдан авч буй болон төлбөрт өгч буй үнэт цаасны харьцаа нь 1 ширхэг “Ард Санхүүгийн Нэгдэл” ХК (MSE:AARD)-ийн хувьцаа тутамд 20 ширхэг “Хөвсгөл” ХК (MSE:HVL)-ийн хувьцаа байна.
- 3.3.5. Хувьцаа эзэмшигч нь өөрийн эзэмшиж буй “Ард Санхүүгийн Нэгдэл” ХК-ийн хувьцааны 50% хүртэлх хэмжээнд эргүүлэн худалдах санал өгөх эрхтэй байна.
- 3.3.6. Хувьцаа эргүүлэн худалдах санал энэхүү Журмын 3.3.3 дахь хэсэгт заасан ширхэгээс давсан тохиолдолд 300 ширхэг хүртэлх “Ард Санхүүгийн Нэгдэл” ХК-ийн хувьцааг 100% биелүүлж, түүнээс давсан саналыг хувь тэнцүүлэн эргүүлэн худалдан авна.
- 3.3.7. Хувьцааг эргүүлэн худалдаж авах саналыг олон нийтэд мэдээлж, захиалгыг 2025 оны 05 сарын 30-ны дотор хүлээн авч, холбогдох төлбөрийг 2025 оны 05 сарын 30-ны өдрөөр тооцно.
- 3.3.8. Энэхүү журмын 2.2 дахь хэсэгт заасан үйл ажиллагааны төлбөрийг эрх бүхий байгууллагуудын холбогдох журам, нөхцөлийг үндэслэн хийнэ.
- 3.3.9. Хувьцаа эзэмшигч нь хувьцааг эргүүлэн худалдаж авах захиалгыг энэхүү Журмын Хавсралт №1 /иргэн/, Хавсралт №2 /хуулийн этгээд/-д заасны дагуу “Ард Секюритиз УЦК” ХХК-д цахим эсхүл бичгээр гаргана.

#### ДӨРӨВ. ХУВЬЦААГ ЭРГҮҮЛЭН ХУДАЛДАЖ АВАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОГЧИЙН БҮРЭН ЭРХ

- 4.1. Көмпанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл (цаашид “ТУЗ” гэх) дараах бүрэн эрхтэй:
  - 4.1.1. Энэхүү журамд нэмэлт, өөрчлөлт оруулах;
  - 4.1.2. Энэхүү журамд заасны дагуу эргүүлэн худалдаж авсан компанийн халаасны хувьцааг буцаан гүйлгээнд оруулах;
  - 4.1.3. Хувьцааг эргүүлэн худалдаж авах асуудлаар хяналт тавих, зөвлөмж гаргах, үүрэг даалгавар өгөх, зогсоох;
- 4.2. Компанийн Гүйцэтгэх захирал нь хувьцааг эргүүлэн худалдаж авахтай холбоотой дараах бүрэн эрхтэй:
  - 4.2.1. Хувьцааг эргүүлэн худалдаж авах ажиллагааг ТУЗ-өөс олгосон бүрэн эрх, энэхүү журамд заасан хурээнд удирдан зохион байгуулах;
  - 4.2.2. Энэхүү журмын хэрэгжилт, эргүүлэн худалдаж авсан хувьцааны талаарх мэдээллийг тухай бүр ТУЗ-д тайлгинах;
  - 4.2.3. Хувьцааг эргүүлэн худалдаж авахтай холбоотой аливаа гэрээ, хэлцэл байгуулах, захиалгын хуудаст компанийн төлөөлж гарын үсэг зурах;
  - 4.2.4. Компани нь хувьцааг эргүүлэн худалдаж авах ажиллагаанд аливаа ашиг сонирхлын зөрчил үүсэхээс сэргийлэх;
- 4.3. Компанийн ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга дараах бүрэн эрхтэй;
- 4.3.1. Хувьцааг эргүүлэн худалдаж авахтай холбоотой мэдээллийг олон нийтэд болон эрх бүхий этгээдэд мэдэгдэх, мэдээллэх;

4.3.2. Компанийн хувьцаа эзэмшигчдэд заавар, зөвлөгөө өгөх, эргүүлэн худалдаж авсан хувьцааг Үнэт цаасны бүртгэлээс хасуулах, Үнэт цаасны бүртгэлийн мэдээлэлд өөрчлөлт оруулахтай холбоотой ажлыг тухай бүрт зохион байгуулах.

#### ТАВ. ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ ХУГАЦАА

5.1. Энэхүү журам нь батлагдсан өдрөөс эхлэн хүчин төгөлдер болно.

\*\*\*

Хувьцааг эргүүлэн худалдан авч,  
халааслах журмын Хавсралт №1

### ХУВЬЦААГ ЭРГҮҮЛЭН ХУДАЛДАХ ХҮСЭЛТ /ИРГЭН/

..... овогтой ..... /РД:...../ миний бие өөрийн эзэмшийн “Ард Санхүүгийн Нэгдэл” ХК-ийн ..... ширхэгийн хувьцааг “Хөвсгөл” ХК-ийн ..... ширхэг хувьцаагаар эргүүлэн худалдахыг “Ард Секюритиз УЦК” ХХК-д зөвшөөрч энэхүү хүсэлтийг гаргаж байна.

**Хувьцаа эзэмшигчийн мэдээлэл /иргэний үнэмлэхний хуулбар хавсаргахыг анхаарна уу.:**

Овог нэр  
Иргэний бүртгэлийн дугаар  
Хаяг  
Утасны дугаар  
Эзэмшиж буй хувьцааны ширхэг  
И-Мэйл хаяг  
Төвлөрсөн хадгаламж дахь дансны дугаар  
Хүсэлт гаргасан огноо  
Гарын үсэг

### Ард Секюритиз УЦК ХХК-ийн бөглөх хэсэг:

Хүсэлт хүлээн авагч  
Хүсэлт хүлээн авсан огноо  
Хүсэлт хүлээн авсан ажилтны нэр

### ҮЦТХТ-ийн бөглөх хэсэг:

Хүсэлт хүлээн авсан огноо  
Хүсэлт хүлээн авсан ажилтны нэр  
Гүйлгээ хийсэн ажилтны нэр  
Хянасан менежер

Хувьцааг эргүүлэн худалдан авч,  
халааслах журмын Хавсралт №2

## ХУВЬЦААГ ЭРГҮҮЛЭН ХУДАЛДАХ ХҮСЭЛТ /ХУУЛИЙН ЭТГЭЭД/

...../Байгууллагын нэр, хэлбэр/ /РД:...../ нь өөрийн эзэмшийн “Ард Санхүүгийн Нэгдэл” ХК-ийн ..... ширхэгийн хувьцааг “Хөвсгөл” ХК-ийн ..... ширхэг хувьцаагаар эргүүлэн худалдахыг “Ард Секюритиз УЦК” ХХК-д зөвшөөрч энэхүү хүсэлтийг гаргаж байна.

**Хувьцаа эзэмшигчийн мэдээлэл** /Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, Гүйцэтгэх захирлын иргэний үнэмлэхний хуулбарыг хавсаргахыг анхаарна уу./:

Байгууллагын нэр, хэлбэр  
Регистрийн дугаар  
Хаяг  
Утасны дугаар  
Эзэмшиж буй хувьцааны ширхэг  
И-Мэйл хаяг  
Төвлөрсөн хадгаламж дахь дансны дугаар  
Хүсэлт гаргасан огноо  
Гарын үсэг/Тамга

### Ард Секюритиз УЦК ХХК-ийн бөглөх хэсэг:

Хүсэлт хүлээн авагч  
Хүсэлт хүлээн авсан огноо  
Хүсэлт хүлээн авсан ажилтны нэр

### УЦТХТ-ийн бөглөх хэсэг:

Хүсэлт хүлээн авсан огноо  
Хүсэлт хүлээн авсан ажилтны нэр  
Гүйлгээ хийсэн ажилтны нэр  
Хянасан менежер